

“ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 03 дугаар сарын 05-ны өдөр

дугаар № 01

Дархан-Уул аймаг

“Дархан нэхий ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Гранд як зочид буудлын хурлын зааланд 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 12⁰⁰ цагт Хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн тоо 906 093 506 ширхэг, буюу 82,0 %-ийн ирштэйгээр хийлээ.

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид:

1. Э. Батсайхан	326 903 000 ш	8. “ННТТ” ХХК	205 704 000 ш
2. Р. Сүмбэнхүү	301 008 000 ш	9. Б. Чанцал	2 341 000 ш
3. Б. Дагвацэрмаа	29 087 000 ш	10. С. Хулан	2 120 188 ш
4. Б. Гэрэлмаа	7 800 000 ш	11. Н. Сарантуяа	303 318 ш
5. С. Норжмаа	2 811 000 ш		
6. Д. Батжаргал	10 803 000 ш		
7. Х. Золжаргал	17 213 000 ш		

Хурлын дарга Э. Батсайхан Дархан нэхий ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын даргаар Д. Ариунтуулаар ахлуулсан комисс ажиллаж байгааг танилцууллаа.

Ариунтуул: Тооллогын комиссын дарга

-Дархан нэхий ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын бүртгэлийг хуулийн дагуу хийж, ирцийг мэдээлж, санал өгөх зааврыг танилцуулав. Тэрээр хувьцаа эзэмшигчид энэхүү хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр санал өгөхдөө батлагдсан саналын хуудас №1-ээр, ТУЗ-ийн гишүүдийг сонгож санал өгөхдөө батлагдсан саналын хуудас №2-оор тус тус бичгээр өгнө. Харин ТУЗ-ийн гишүүнийг сонгох санал өгөхдөө Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 09 сарын 09-ны өдрийн 880 тоот тогтоолоор шинэчлэн баталсан “Санал хураах кумулятив арга хэрэглэх журам”-ыг баримтлан санал өгнө гээд уг журмыг тайлбарлан танилцууллаа.

Хурлын дарга Э. Батсайхан:

-Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид ээ! Та бүхний өдрийн амгаланг айлтгая.

-Тооллогын комиссын мэдээллээр хуралд оролцох Хувьцаа эзэмшигчдийн ирц 82,0%-тай байгаа тул хурлын ирцийг хангалттай гэж үзэж хурлаа эхлүүлж байна. Хурлын дэг ёсоор хэлэлцэх асуудлыг, асуудал тус бүрээр хэлэлцсэний эцэст хувьцаа эзэмшигчид батлагдсан саналын хуудсаар саналаа өгч, тооллогын комисс эцсийн шийдвэрийг гарган дүнг танилцуулна. Дархан нэхий ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээж /Өнөөдрийн хурлаар 7 асуудлыг хэлэлцэнэ. Одоо хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцууля.

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Компанийн тухай хуулийн 96.4-д заасан тайланг танилцуулах
3. ТУЗ-ийн гишүүнийг сонгож батлах
4. ТУЗ-ийн төсөв батлах /цалин урамшууллын хэмжээг тогтоох/
5. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-өөс гаргасан шийдвэрийг батлах
6. Аудитын байгуулага сонгож батлах
7. Хөрөнгө татах тухай асуудал /төслийг/ хэлэлцэж батлах

Хэлэлцсэн нь:

1 ба 2-р асуудал:

КтХ-ийн 96.4-д заасан ТУЗ-ийн тайланг хурлын дарга Э. Батсайхан, ДНХК-ийн үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайланг Б. Мягмар-Өлзий нар тус тус дэлгэцээр танилцуулав. /тайлангуудыг хавсаргав./

Э. Батсайхан:

-Хэрэв та бүгд ажигласан бол тайлангуудад борлуулалтын орлого зөрүүтэй мэт харагдаж байгаа. Энэ нь сангийн яамны тайлангийн нэгтгэлээр компани хоорондын борлуулалт, үйлчилгээний орлого тооцогддоггүй нь энэ байдлыг үүсгэж байдаг. Цаашид эдгээр орлогыг тооцож байх нь борлуулалтын орлого буурахгүй. Бодитоор тусгагдах юм. Тайлангаас асуух зүйл байвал асуугаарай.

3-р асуудал:

Х. Золжаргал: Хурал зохион байгуулах комиссын дарга /Энэ асуудлыг дэлгэцээр танилцууллаа/.

-ТУЗ-ийн гишүүнийг сонгож, батлах асуудлыг хэлэлцье. ТУЗ-д нийтдээ 10 иргэн нэр дэвшсэн бөгөөд үүнээс ТУЗ-ийн ердийн гишүүнд 6 иргэн, хараат бус гишүүнд 4 гишүүн тус тус нэр дэвшсэн байна. Нэр дэвшигчдийн анкет, хараат бус гишүүний шалгуурыг хангасан эсэх талаархи мэдээллийг нэр дэвшигч тус бүрээр товч танилцууллаа. ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал өгөхдөө шинэчлэн баталсан санал хураах кумулятив арга хэрэглэх журам”-ын дагуу өгөхийг дахин санууллаа.

Э. Батсайхан:

-Гишүүдийн анкеттай танилцлаа. Санал өгөхийн өмнө зарчмыг тохирох хэрэгтэй байна. ТУЗ дүрмээр есөн гишүүнтэй байна. Харин 9 гишүүний хэд нь ердийн, хэд нь хараат бус гишүүн байх бэ гэдгийг тогтоож ярилцъя. Ердийн гишүүн 6, хараат бус гишүүн 3 байх уу, эсвэл ердийн гишүүн 5, хараат бус гишүүн 4 байх уу.

Х. Золжаргал:

- КТХ-ын 75.4-д Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь 9 ба түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна гэж заасан байдаг. Иймээс ердийн 5 гишүүн, хараат бус 4 гишүүнтэй ч байж болно.

Э. Батсайхан:

ТУЗ-д ахмад ажилтны төлөөлөл байх хэрэгтэй гэж үзэж байна. Энэ жил 50 жилийн ойтой. Ахмадуудад зориулсан арга хэмжээ нилээд зохион байгуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Одоо дараагийн асуудалд орё.

4-р асуудал:

ТУЗ-ийн төсвийн төслийг ТУЗ-ийн дарга ТУЗ-ийн дарга Х. Золжаргал танилцуулав. Төсвийг хавсаргав.

Э. Батсайхан:

- Жил жилийн ТУЗ-ийн төсөвт хэрэглэгддэггүй зардал байдаг. Энэ бол томилолтын зардал, заавал байх асуудал биш. ТУЗ-ийн ажлаар хэзээч томилолтоор явдаггүй. Явахдаа компанийн ажлаар явбал компаниас томилолт авч явж байх.

5-р асуудал:

Э. Батсайхан:

- Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн 2022 оны 02 сарын 11-ны өдрийн 02/01 тоот тогтоолыг уншиж танилцуулаад, ногдол ашиг хуваарилах нь ТУЗ-ийн эрх мэдлийн асуудал боловч ХЭХ-аар батлах нь зүйтэй байдаг.

- Компани энэ жил том ашиг хуваарилаж болох байсан боловч оны өмнө өндөр зээл авсан. Хувьцаа эзэмшигчдээс илүү баялаг бүтээж буй ажилчдад хувь хүртээх зорилгоор хөрөнгө оруулалт хийсэн. Энэ зээлийг төлж дууссан үед хөрөнгө оруулалт хийх, мөн ойн жил учир зардал их гарна.

Н. Сарантуяа: Хуралд оролцогч

- Химийн маериал яаж авдаг вэ. Хүндрэл байдаг уу.

Э. Батсайхан:

- Хүндрэлд орсон. Өнгөрсөн жил захиалсан зарим бараа материал Хятадын гааль дээр гацсан. Одоо ч гааль дээр байгаа. Бид тооцож Орос ТУРК руу эргэсэн чинь тэнд дайн боллоо. Өнөөдөртөө транзит тээвэр зогсоогүй байгаа. Цаг үе ямраар ч эргэж мэднэ. Рублийн ханш унасан байна. Үүнийг ашиглаж чадвал ашигтай.

Н. Сарантуяа

- Оросын химийн үйлдвэрүүдийг судлаж үзсэн үү.

Э. Батсайхан:

- Оросын химийн үйлдвэрүүд зогссон ажиллагаа муу байгаа. Бид давс, будаг, этилен авч байсан.

6-р асуудал:

Д. Батжаргал:

- Манай компанитай 3 жилийн гэрээтэй "ЦЭСБ-Аудит" ХХК хамтран ажиллаж байгаа энэ компанийг үргэлжлүүлэн ажиллуулах сонголт хийж батлах саналыг оруулж байна.

Х. Золжаргал:

- Үргэлжлүүлэх санал оруулж байна.

7-р асуудал

Х. Золжаргал:

- Хөрөнгө татах асуудлыг энэ удаад хойшлуулах нь зүйтэй гэж үзэж байна. Одоо хэрэгжүүлэх хугацаа нь биш. Өндөр үнэтэй үнэлгээ гарч байна. Цаг үеийн байдал дээрдсэн нөхцөлд хэрэгжүүлье.

Э. Батсайхан:

- Харин би эсрэг саналтай байна. Энэ асуудлыг батлах нь зүйтэй.

Н. Сарантуяа:

- Хувьцаагаа худалдаж авах уу.

Х. Золжаргал:

- Боломж байвал бид энэ асуудал руу зорино. Өөрсдийн дотоод нөөц бололцоо, андрейторуудын үнэлгээ буухыг хүлээх, судлах гэх мэт асуудлууд байгаа учир хойшлуулах

Э. Батсайхан:

- Балансад тусгагдсан дуусаагүй хөрөнгө оруулалт байгаа. Үүнийг дуусгах хэрэгтэй. Гадаад харилцаа, зах зээл, цаг үеийн байдлаас болж 2 жил хойшилсон байгаа.

- Нөгөө талаас энэ асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлд эрх өгөөд нээлттэйгээр орхих нь зүйтэй гэсэн саналтай байна. Цагийн байдлыг харж ТУЗ шийдвэрлэх

Н. Сарантуяа:

- Усны ашиглалтын талаар ямар арга хэмжээ авдаг вэ.

Э. Батсайхан:

- Энэ асуудлыг байнга хэрэгжүүлж байгаа. Үйлдвэрийн хэрэглээний ус, мөн тос авах машины хэрэглээний усыг, саарал ус болгон дахин ашиглаж байгаа. Ер нь 1 шир боловсруулахад 150л ус ордог. Иймээс тодорхой хөрөнгийг усны дахин ашиглалтанд зарцуулж байгаа.

- За хурлын асуудлуудыг хэлэлцэж дууссан бол саналын хуудсаа бөглөхгөө.

Ингээд хурлаар хэлэлцэх асуудлыг хэлэлцэж дууссан тул хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар саналаа өгч, тус бүрийн саналын хуудсыг тооллогын комисс хүлээн авч, дүгнэн эцсийн дүнг танилцуулж, Дархан нэхий ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 01, 02, 03, 04 тоот тогтоолд тусгасан шийдвэрийг тооллогын комиссын дарга Д. Ариунтуул уншиж танилцууллаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналын дүн:

1.Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг батлах, Компанийн тухай хуулийн 96.4-д заасан тайланг батлах, ТУЗ -ийн гишүүн сонгох, ТУЗ-ийн төсвийг батлах, Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-аас гаргасан шийдвэрийг батлах, Аудитын байгууллагыг батлах, Хөрөнгө татах асуудлыг батлах, шийдвэр гарсныг танилцуулав.

2.ТУЗ-ийн гишүүдийг сонгох саналын дүн:

Санал хураалтаар доорхи 9 гишүүнийг ТУЗ-ийн гишүүнээр сонгож, үүнээс хараат гишүүнд 6, хараат бус гишүүнд 3 гишүүн сонгогдсон тухай дүнг танилцуулав.

1.ТУЗ-ийн ердийн гишүүнээр:

1. Эрдэнэдалайн Батсайхан - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 82 хувийн саналаар;
2. Равжаагийн Сүмбэнхүү - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 82 хувийн саналаар;
3. Батсайханы Чинчулуун - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 82 хувийн саналаар;
4. Сүмбэнхүүгийн Хулан - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 82 хувийн саналаар;
5. Батсайханы Мягмар-Өлзий - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 82 хувийн саналаар;
6. Баасангийн Гэрэлмаа - Хуралд оролцогчдын 59% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 48,2 хувийн саналаар

2. ТУЗ-ийн хараат бус гишүүнээр:

7. Далхжавын Батжаргал - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 82 хувийн саналаар;
8. Баатарын Бурмаа - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 82 хувийн саналаар
9. Хумбагийн Золжаргал - Хуралд оролцогчдын 99,7% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 81,8 хувийн саналаар;

тус тус сонгогдсон байна.


Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 03 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаас дараах шийдвэрийг гаргалаа.

Хурлын шийдвэр:

1. Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн гүйцэтгэлийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг батлах
2. КТХ-ийн 96.4-д заасан ТУЗ-ийн тайланг батлах
3. Дархан нэхий ХК-ийн ТУЗ-ийн хараат болон хараат бус гишүүдийг сонгох
4. Дархан нэхий ХК-ийн 2022 оны ТУЗ-ийн зардлын нийт 94,0 сая төгрөгийн төсвийг батлах
5. “Ногдол ашиг хуваарилах тухай” ТУЗ-ийн 2022 оны 02 сарын 11-ний өдрийн 02/01 тоот тогтоолыг батлах
6. Аудитын байгууллагаар “ЦЭСБ-АУДИТ” ХХК –ийг үргэлжлүүлэн ажиллуулах тухай ДНХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны саналыг дэмжиж батлах
7. “Хөрөнгө татах асуудал”-ыг батлаж, зах зээлийн нөхцөл байдал, үнэ үнэлгээг нарийвчлан судалж, дахин тооцоолон хэрэгжүүлэх ажлыг нээлттэй үлдээх, мөн тодорхой нөхцөл байдлын боломжит хугацаанд шийдвэрлэн хэрэгжүүлэхийг Дархан нэхий ХК-ийн ТУЗ -д зөвшөөрөх

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ТАНИЛЦСАН:



Х.НАРАНТУЯА

Э. БАТСАЙХАН